



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/94

Улаанбаатар хот

Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн  
судалгаа зохион байгуулах  
Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/16-А/04 дүгээр хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал”-аар нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг хавсралтаар томилсугай.

2.Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2023 оны 05 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд аргачлал, зааврын дагуу чанар, үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т даалгасугай.


3.Судалгаа зохион байгуулсан тухай тайланг 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн дотор танилцуулахыг нарийн бичгийн дарга (Д.Энхтайван)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 08 дүгээр сарын 17 ны өдрийн  
А.1.94 дугаар захирамжийн хавсралт



ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН СУДАЛГАА  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Б.Болормаа	Засаг даргын Эдийн засаг нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Энхтайван	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга